

**ЯРУУ ИЛЭРХИЙЛЭХ УТГЫГ
ТАНИХУЙН ҮҮДНЭЭС МӨШГИХ НЬ**

Ж. Баянсан *

Орчин үеийн хэлшинжлэл нь бүхэлдээ хүн төвт (anthropological) чиг барих болсон нь санамсаргүй зүйл биш ажээ. Учир нь хэлний аливаа үзэгдэл баримтыг судлахдаа түүнийг үүсгэн ашиглагч хүний мөн чанар, тэдгээрийн харилцах хэрэгцээнээс нь ангид авч үзэх боломжгүй байдагтай холбоотой байна. Ертөнцийн юм үзэгдэлд хүн өөрийнхөө хэмжээсээр хандаж харьцдаг нь хүн төвт буюу бие төвт хэмжээс (anthropometric) хэмээх нэгэн зүйл аргачлалыг судалгааны хүрээнд оруулж ирэхэд хүргэжээ. Дорно дахины нэгэн үлгэрт намгийн мэлхий, худгийн мэлхий хоёр ертөнцийг өөр өөрийнхөө оршдог газраас тольдон төсөөлдгөө мэтгэлцэн хэлэлцдэг ёгт өгүүлэмж гардаг нь чухамдаа хүн бидний сэрж мэдрэх, төсөөлж таамнах сэтгэцийн зайлшгүй шалтгаацимал үйлдлийг л амьтаншуулж өгүүлсэн төдий гэдгийг эргэцүүлж бодох нь утгагүй хэрэг биш бололтой. Хэлний илэрхийллийн өнгөн бүтэц нь харилцагчдын ухамсрын агуулгатай хэм тэнцүү нийцэж байх албагүйн жишээг М.Ядамсүрэнгийн “Ухваргүйн ярилцаан” өгүүллэгт газарзүй, эрдэс судлалын эрдэмтэн, айлын эхнэр хоёрын ярианаас жишээлэн тусгаж ч болно. Ийн санавал, үлгэр домог, уран зохиолд амьтаншуулах, хүншүүлэх, юмшуулах зохиомж, өгүүлэмж хаа сайгүй гардаг нь дээр тэмдэглэсэн, хүн төвт үзэл, бие төвт хэмжээс бүхий сэтгэлгээний бэлээхэн баримтууд гэдгийг тэмдэглэн орхиё. Ийм учраас тогтолцоог үүсгэх хүчин зүйлийн хүрээнд хэлний чадварыг тодорхойлоход ямар зүйл чухал учир холбогдолтой байдаг вэ? гэвэл, тухайн хэлийг харилцааны хэрэглүүр болгон ашиглах бүтэц байгууламжийнх нь бүх дүрмийг төдийгүй, тухайн хэлийг төрөлх хэлээ болгосон үндэстэн угсаатны ертөнцийг үзэх үзэл, ертөнцийг таньсан байдал, соёлын онцлогийг биедээ цогцлоосон бие хүн байдгийг хүн төвт хэлшинжлэлийн гол судлагдахуун болгох учиртай болно.

Харилцахуйн орчилд л хэлний жинхэнэ үүрэг тодорхой болж хэрэгжинэ. Харилцах гэдэг нь санаа бодлоо бие биедээ зүгээр л илэрхийлж байхын нэр огтхон ч биш, харин өгүүлэгч, сонсогчийнхоо эрэмбийг харилцан сэлгэж буй наад зах нь хоёр этгээдийн танин мэдэх, хийсвэрлэн сэтгэх үйл ажиллагааны эрчимтэй харилцан урсгал байдаг. Иймд өгүүлэгч, сонсогч хоёр нь харилцах үйл ажиллагааг зохируулан найруулагч гол төв болох нь илэрхий байна. Энэ үйл ажиллагаа нь дотооддоо хэд хэдэн үелрэлтэй байхаас өөр аргагүй. Тухайлбал, байгаль, нийгмийн ямар нэг юм үзэгдлийн тухай хүн эргэцүүлэн бодож эхэлнэ. Ингэх явцдаа уг зүйлийг өөрийн хэрэгцээ сонирхол, эрх

* МУИС-ийн МХСС-ийн Хэл шинжлэлийн тэнхим

ашгийн үүднээс үнэлж цэгнэх нь бас зайлшгүй байна. Ийн үнэлж цэгнэхдээ түүний талаар сэтгэл хөдөлж байгаа бол тэр байдлаа нийгэмшсэн харилцааны тухайн орчилд нийцүүлэн илэрхийлэх аргаа бас бодолхийлж товлон. Чингээд харилцах зорилгодоо уялдуулан хэлний хэрэглүүрийг олж сонгоод, тэдгээрийг хэлний махбодийн зохирол буюу хэлзүйн дүрмээр найруулан илэрхийлснээр харилцахыг зорьсон зөвхөн өгүүлэгчийн хэлэхүйн үелрэл дуусна. Харин нөгөө харилцагч буюу сонсогчийн үйлдэл нь өгүүлэгчийн үйлдлийн эсрэг эрэмбээр хэрэгжинэ. Ингэснээр хэлэхүйн харилцааны эхний шат бүрэлдэж байгаа хэрэг. Харин хоёрдох шатны гол онцлог нь эхний шатан дахь өгүүлэгч, сонсогчийн харилцааны эрэмбэ буюу байр нь солигдох болно. Ийм хоёр зүйлийн үелрэл буюу эрэмбээр хэлэхүйн харилцаа хэрэгжинэ.

Харилцааны хэрэглүүрийг хэрэглэгчтэй нь хэрхэн авалцуулж тайлбарлах талаар янз бүрийн санал дүгнэлт гарсны нэлээд түгээмэл нь Ф.де Соссюрийн дэвшүүлсэн хэл(*langue*), хэлэхүйн үйл ажиллагаа(*language*), хэлэхүй(*parole*) хэмээх гурвалсан бүтэц ажээ. Оросын хэлшинжлэлд хэлэхүйг гадаад хэлэхүй, дотоод хэлэхүй хэмээн ангилж үздэг нь зарим талаараа, Соссюрийн гурамсан бүтцийн сүүлийн хоёрыг багталцуулсан тайлбар гэж хэлж болно. Гэвч А.А.Леонтьевийнхээр дотоод хэлэхүй буюу “дотоод програмчлал” нь Хэлэхүйн үйл ажиллагааны онолын үүднээс дотроо 5 зүйлийн үе шатаас бүрддэгийг туршилт судалгаагаар нотолсон байдгаас үзвэл хэлний аливаа илэрхийлэл, тэр тусмаа хэлний хийсвэрлэлийн хамгийн дээд эрэмбийн үзэгдэл баримтад зүй ёсоор хамаарах хэлц нэгжийн утга үүсэх, түүнийг ойлгох хэл-сэтгэцийн оньсыг загварчлан тайлах асуудал нь нэн ээдрээтэй болохын хувьд түүнд аргагүйн ямар өргөтгөл хийх ёстой бэ? гэдэг асуудал судлаачдын сэтгэлийг эзэмдэж ирсэн нь тодорхой байдаг. Тухайлбал, Кофенский¹ хэлний илэрхийллийн утгын бүрэлдүүлбэрийг бүрэнилрүүлэхдээ хүн төвт үзэл баримтлалыг чиг болговол дараах загвар тохиромжтой болно гэжээ. Энэ нь: Хэл – Хэвшмэл хэрэглээ (узус) - Хэлэхүйн үйл ажиллагаа – Журамламал хэрэглээ(норм) – Хэлэхүй хэмээгч парадигм байж болно гэж томъёолсон байна. Соссюрийн гурамсан холбооноос тооны хувиар олон буюу таван бүрэлдүүлбэртэй байна. Гэвч энэ бол зөвхөн тооны ялгаа төдий биш, агуулгын бүтцийг тайлбарлахад нэлээн зохимжтой нэгэн томъёолол гэдгийг В.Н.Телия² бас чухалчилж үзсэн байна. Бид энэ өгүүлэлдээ тэдгээрийн санааг үндэс болгож, монгол хэлний жишээ баримтад харгалзуулан үзэх боломжийн талаар хэдэн зүйл тэмдэглэж байна.

Бидний сонирхлыг татаж байгаа асуудал бол хэлний илэрхийлийн ил ба далд утгын харьцаа хамаарал ямар байдгийг, тэр тусмаа далд утгыг нээгдүүлж гаргах боломжийг эрж олоход чиглэж байгаа билээ. Учир нь төрөлх хэлээрээ харилцаж байхад ярианд хэрэглэгдэх илэрхийлэл болгон тэдний хувьд жирийн л зүйл байдаг боловч ингэж хэлдэг билүү?, үгүй билүү? гэх буюу ингэж хэлж болох уу?, үгүй юу? гэдэг асуулттай, анзаардаггүй л болохоос биш, алхам тутам тулгарч байдаг. Үүний цаана, ямар учраас ингэж ярьж болохгүй вэ?, тэгвэл ямар учраас ингэж ярьдаггүй вэ? гэдэг асуудалд хэргийн учир нуугдаж байгаа гэж үзнэ. Бид ямар нэг гадаад хэл сурч судалж байхад юм уу, эсвэл гадаад хүн бидний төрөлх хэлийг сурч судлах явцад хэн хэнийх нь төрөлх хэлээрх харилцаанд нь урсан өнгөрч байдаг тэр л “эгэл жирийн” зүйлснэ заримдаа учир

¹ Кофенский, J. Kevztahumovecнiя specialnelingvistickйteoriesystim // К принципоммарксистическойязыковедy. Bratislava, 1985.

² В.Н.Телия. Механизмы экспрессивной окраски языковых единиц // Человеческие факторы в языке: Языковые механизмы экспрессивности. Москва, 1991.

битүүлэг, заримдаа бүр энгүй хэцүү бэрх болж мэдрэгддэг баримтыг санах ёстой болно. Жишээлбэл, 1. Хормойгоороо гараа арчив. 2. Хормойдоо гараа арчив. 3. Хормойгоороо нүдээ арчив. 4. Хормойдоо нүдээ арчив³ гэсэн 4 өгүүлбэрийг утгаар нь харьцуулбал, 4 дэх өгүүлбэрийг монгол төрөлх хэлтэн: - монголоор ингэж ярьдаггүй гэж хэлнэ. Гэтэл гадаадын хүнд 1, 2 дугаар өгүүлбэр зөв бол түүнтэй адил аргаар бүтсэн 3,4 дүгээр өгүүлбэрүүд мөн л зөв болох ёстой гэж санах нь зүйн хэрэг билээ.

Тэгэхлээр 4 дэх өгүүлбэр бол хэлний хэвшмэл хэрэглээ буюу “узус”-ын хамаатай асуудал болно. Бид 4 дэх өгүүлбэрийн утгыг анзаарвал “тэгж ярьдаггүй” гэж хэдийгээр хэлж чадах боловч ер нь ийм үзэгдэл байж болох уу?, үгүй юу? гэж эргэцүүлэн бодож үзвэл, хэдийгээр ингэж ярьдаггүй ч гэсэн толгойгоо гудайсаар хормойдоо хүргээд нүдээ түүнд арчиж чадвал ингэж хэлэх бас бололцоотой юм байна гэсэн нэг тайлал гарч болно.

Тэгвэл хэвшмэл хэрэглээ буюу узус гэдэг нь түгээмэл харилцаанд хэдийгээр хэрэглэгддэггүй ч гэсэн бас байх цагтаа байж болох үзэгдлийг багталцуулсан хэлний тэмдгийн нийлц гэж үзэж болно. Үүндүгээс эхлээд чөлөөт ба чөлөөт бус холбоо үг, бичил эх хүртэл хамаарч болно.

Харин журамламал хэрэглээ буюу норм гэдэг нь хэлэхүйн үйл ажиллагаа, хэл хоёрыг дүрэм журам хэм хэмжээнийх нь үүднээс алдааг нь засч залруулж, тэдгээрийг цэвэр ариун байлгах зорилгод үйлчилж байдаг үзэгдэл гэж хэлж болно.

Ийнхүү хэвшмэл хэрэглээ, журамламал хэрэглээ хоёр нь хэлэхүйн үйл ажиллагааны хоёр бүрэлдэхүүн болохын хамт хэлж харилцах үйл ажиллагааны хөдлөнг шинжийг тодорхойлон загварчлах нэг шижим болж байна гэж үзнэ. Ингэж үзвэл хэлэхүйн үйл ажиллагаа бол хэл, хэвшмэл хэрэглээ, журамламал хэрэглээ гурвыг багталцуулсан хэлсэтгэцийн “үүтгэн төрүүлэгч” оньс бөгөөд уг үйл ажиллагааны төгсвөр нь даруй хэлэхүй болно⁴.

Эндээс үзвэл хэлэхүйн үйл ажиллагаа нь нэг талаараа хэвшмэл хэрэглээ, нөгөө талаараа журамламал хэрэглээтэй харилцан хамаарсан харьцаатай байж, харин хэвшмэл хэрэглээ нь хэлнээсээ шалтгаалан хамаарсан байдаг бол журамламал хэрэглээ нь хэлэхүйг үүсгэх хамаарал, зүй тогтолтой байна. Ингэхдээ хэлний үзэгдэл баримт нь хэвшмэл хэрэглээ, хэлэхүйн үйл ажиллагаа, журамламал хэрэглээг багталцуулан хэлэхүйн үүтгэл болдог бол хэлэхүйн баримт нь хэлнийхээ мөн чанараас шалтгаалан хамаарсан эргэх холбоотой байна гэж үздэг. Энэ нь хэлний илэрхийлэл дэх объектив, субъектив хүчин зүйлийг зайлшгүй анхаарах учиртай⁵ сануулж байгаа хэрэг юм.

Чингээд хэлэхүйн үйл ажиллагаа нь хэл, хэвшмэл хэрэглээ, журамламал хэрэглээний сан хөмрөг, арга боломжоос объектив хүчин зүйлүүдийг сонгож аваад тухайн нийгмийн харилцааны тогтсон хэм хэмжээнд зохирсон “дундаж” илэрхийллийг үүсгэдэг нь субъектив хүчин зүйлээс харьцангуй хөндий байдаг гэж хэлж болно. Энэ бол нэг зүйлийн “хуурай” мэдээлэл юм. Гэтэл хэвшмэл хэрэглээ нь мөн энэ агшинтай давхцан бодолсанаагаа аль болох чөлөөтэй илэрхийлэх боломжийг тухирах хандлагатай байна. Учир нь журамламал хэрэглээг бодоход хэвшмэл хэрэглээ нь олон, нэг санааг олон хувилбараар илэрхийлэх боломжийг үгүйсгэхгүй байдагтай холбоотой ажээ.

³⁾ Е.А.Кузьменков. Глагол в монгольском языке. Ленинград, 1989 . номдоо авсан жишээг энд ишлэв.

⁴⁾ Телия-гийн өмнө тэмдэглэсэн бүтээлээс нь дэлгэрүүлэн үзнэ үү.

⁵⁾ Г.В. Колшанский. Соотношение субъективного и объективного факторов в языке. Москва, 1975

Жишээлбэл, монголоор *цагийн ажил* гэвэл тогтсон цаг хугацаанд хийх ажил гэсэн ч утгатай, бас цаг засах ажлыг ч ингэж хэлж болдог байсан бол одоо *цагны ажил* гэдэг гэдэг журамламал бус бүтэц нь цаг засах ажлын нэрлэлт болсон хувилбар үүсч, хэвшмэл(узус) хэрэглээнд орж хэрэглэгдэх болсон байна. Түүнчлэн нэр хүндтэй хүн хоол идэхийг *зооглох* гэж хэлэх нь эрхэмсэг найруулгын журамламал хэрэглээний илэрхийлэл бөгөөд түүнийг *гудрах* юмуу, эсвэл *цуслах* гэж хэлж болохгүй нь бас энэ хэрэглээний үзэгдэл болно. Гэтэл тухайн хоёр хүний хувийн харилцааны шинжээс хамааран тэд бие биенээ хүндэтгэх байтугай, үзэн ядалцдаг болсон үед хүндэтгүүштэй хүнээ “хоол цуслах, гудрах” гэж хэлэх нь зайлшгүй, “зохистой” илэрхийлэл ч байж болдог нь хэвшмэл хэрэглээний хувилбарт шинжид хамаатай жишээ хэмээн ойлгож болох юм. Энэчлэн аав ээжийгээ ихэмсэг зан байдал гаргаж байгааг үр хүүхэд нь мэдэрч, түүнийгээ илэрхийлэхдээ “хамраа сөхөх, сүүлээ сөхөх” гэж хэлж болдоггүй нь нийгэмшсэн харилцааны журамламал хэрэглээтэй холбоотой, хүн бие биенээ таньсан танилтаас үүдэлтэй баримт болно. Өөрөөр хэлбэл, нас бие, эрхэлж буй ажил мэргэжлийн зиндаагаараа тэнцүү хүмүүсийн хооронд ийм илэрхийлэл зохистой байх боломж бий гэдэг санааг хэлж байгаа юм. Иймд “ертөнцийн зураг” гэдэг томъёололын агуулгад авч үздэг зүйлүүд нь бүхэлдээ хэвшмэл хэрэглээнд хамаатай болохоос биш, хэлэнд шууд холбогдолгүй юм. Ийм учраас хэвшмэл хэрэглээ нь “ертөнцийн зураг”-ийг боловсруулах багаж зэмсэг болгох маягаар журамламал хэрэглээний үзэгдэл баримтыг ашигладаг. Ингэснээрээ хэрэглээнээс гарсан “хуучин” зүйлсийг орхиж, шинэ шинэ “жирийн” зүйлээр баяжин өргөсөж байх зүй тогтолтой байна. Хэлний илэрхийлэлд үүсдэг элдэв “гаж” үзэгдлүүдийн олонх нь ийм хандлагаар бий болдог гэж болно. Үүнд жаргон, арга зэрэг метафорын хувилбарууд ч хэрэглээнийхээ хэрэгцээ, онцлогоороо тус тус зүйлчлэгдэн хамрагдах боломжтой болно. Жишээлбэл, 70-80-аад онд төлбөрөө төлөлгүй, хулгайчлан мэхэлж унаагаар зорчихыг “туулайчлах” гэж нэрлэдэг. Энэ үйл явдлыг оросын “Ну, погоди!” хэмээх хүүхэлдэйн алдартай кинонд хүртэл дүрслэн үзүүлсэн байдаг. Тэгвэл одоо нийгэмшлийн хууль, түүнийг зохируулан хэрэгжүүлэх үйл ажиллагаа, дүрэм журам ёсоор төлбөрөө хийж, тасалбар авалгүйгээр унаагаар зорчих боломжгүй болохлоор энэ хэллэг мартагдах шахсан нь “цэвэр” хэлний хүчин зүйл арайхан биш гэдэг нь илэрхий байна. Энэчлэн 1990-ээд онд “гахай чирэх, зөөх” гэдэг метафорчилж үүссэн хэллэг эхэндээ сонин хачин, гаж этгээд байдалтай сонсогддог хэрнээ түгээмэл хэрэглэгдэж байснаа одоо төдий л дуулдахгүй болсон нь хэлний хүчин зүйлтэй шууд холбогдолгүй, харин нийгмийн амьдралд өрнөж буй үйл явдал, түүнийг зохицуулж, үйлдэж байгаа хүмүүсийн харилцааны хэрэгцээ шаардлага, онцлог нөхцөлөөс үүдэлтэй үзэгдэл болох нь тодорхой байна. Ингэхлээр зөвхөн хэлний тэмдгээр илэрснийхээ хувьд л иймэрхүү баримтыг дан ганц хэлний үзэгдэлд тохоон тайлбарлах гэж оролдох нь зөв гаргалгааг мухардалд оруулж болзошгүй байдгийг анхаарах ёстой болж байна.

Тэгвэл хэлэхүй нь субъектив хүчин зүйлүүдийг хэл, хэвшмэл хэрэглээ, журамламал хэрэглээний сан хөмрөгт буцаан хадгалах үйлдэл, үүрэгтэй байна. Ингэхдээ субъектив хүчин зүйлүүд нь тухайн илэрхийллийг хүлээн авч ойлгох сонсогч, уншигчийн шүүлтүүрээр орж, гаж жигтэй биш, харин жирийн, хэвийн зүйл мэтээр объектив шинжтэй болж хэрэглэгдэх боломжтой байна гэсэн үг. Жишээлбэл, сүүлийн үес “хуурах мэхлэх” гэдэг санааг “хулхидах”, “хошгируулах” гэх мэтээр зүйрлэн хэлдэг болсон байна. Энэ илэрхийлэл ч гэсэн хачин гаж сонсогдохоо больж, чихэнд дасагнаж байна. Ер нь дасах зохицох гэдэг бол байгаль, нийгмийн түгээмэл үзэгдэл, гарцаагүй хууль юм.

Дасч зохицохгүйгээр, зохирч нийцэхгүйгээр энэ орчлон ертөнцөд урьдаас байсан нь ч тэр, одоо байгаа нь ч тэр, “шинээр” бий болохын аль нь ч тэр оршин тогтнох аргагүй болно. Энэ хуулийн үйлчлэл орчин үед зүйрлэшгүй учир холбогдолтой, бас их эрч хүчтэй болсоор байгаагийн гэрч нь англи хэлээрх эрдэм шинжилгээний төдийгүй, ер хэн хүнд зориулсан ухуулга сурталчилгаа, таниулга мэдээлийн зохиол бүтээлд “адилсах, адилсуулах,” гэсэн шиг утгатай “identify, identification” гэдэг үг оролцсон холбоо хэллэг, илэрхийлэл олонтаа дайралдах болсон санамсаргүй зүйл биш байхын хамт бас л хэлний хүчин зүйлтэй шууд хамааралгүй, харин “даяарших” хэмээх нийгэмшлийн үзэгдлийг хэлний тэмдгээр тэмдэглэсэн зүйл гэж үзэх ёстой биз.

Өөрөөр хэлбэл, хэлж харилцах гэдэг бол бодит байдлын юм үзэгдлийн тухай ерийн мэдээлэл төдий зүйл огтхон ч биш, харин өгүүлж байгаа юм, үзэгдэл, хэрэг явдал, чанар шинж, нөхцөл байдалд өгүүлэгч хэрхэн хандаж байгаа, бас түүнийг сонссон хүн уг зүйлд хэрхэн хандах боломжтой хийгээд яаж хандуулахыг зорьж байгаа гэх мэт сэдэл, үүтгэл санаанууд давхар давхар, ил далд илрэх нь зайлшгүй гэдэгт энэхүү субъектив хүчин зүйл гэдэг томъёоллыг оруулан хэрэглэдэг болсон ажээ.

Хэлний сэтгэл судлалын аргазүйг чиг баримжаа болгосон сүүлийн үеийн зарим судалгаанд зорьсон санаа (intention гэдэг нэрлэлтэд дүйлгэн ойлгох боломж бий) гэдэг үг хэллэг түгээмэл дайралдах болсон нь хэлний нэгжийн үндсэн утгын дотоодод биш, харин харилцахуйн тодорхой орчинд түүнийг дагалдан, бас түүнд давхраатан илэрч байгаа сэтгэл хөдлөл, үнэлэмжид хамаатай янз бүрийн онцолмол утга (connotation)-ыг нээж тодорхойлоход чухал учир холбогдолтой болж байна.

В.Н.Телия-гийн дэвшүүлснээр⁶, хэлний илэрхийллийн утгын макро бүтэц нь:

- хэлзүйн бүрэлдүүлбэр (грамматический),
- нэрлэмэл бүрэлдүүлбэр (денотативный),
- шалтгаанчлал бүрэлдүүлбэр (мотивационный),
- үнэлмэл бүрэлдүүлбэр (оценочный),
- сэтгэл хөдлөлийн бүрэлдүүлбэр (эмотивный)

- найруулгын бүрэлдүүлбэр (Стилистический) гэсэн таван зүйлээс тогтно гээд үүнээс эхний хоёр нь аливаа илэрхийлэлд заавал илрэх бүрэлдүүлбэр бол сүүлийн гурав нь өгүүлж байгаа зүйлдээ өгүүлэгч хэрхэн хандаж байгаа харьцаа хандлагыг илэрхийлэх маш чухал үүрэгтэй бүрэлдүүлбэр болно гэдгийг онцолсон нь ялангуяа хэлцэжсэн илэрхийлэл, хэлц нэгжийн гүн бүтэц, түүний үүсэх сэтгэцийн далд эрэмбийг зөв ойлгож талбарлахад аргазүйн чухал холбогдолтой гаргалга дүгнэлт болж байна.

Харин А. Wierzbicka⁷ хэлний илэрхийллийн харилцааны утга үүргийг тодорхойлохдоо: “Би (ингэж) мэдэж байна. Чи (бас тэгж) мэдэж байна уу?” гэсэн эрэмбээр хэлэлцдэг гэдгийг иш үндэс болгох ёстой хэмээсэн чухал санааг нь В. Н.Телия улам гүнзгийрүүлэн тайлбарлах арга зарчмыг тодорхойлжээ гэж санагддаг. Өөрөөр хэлбэл, өгүүлж байгаа зүйлдээ хандах хандамж буюу үл тоомсорлох, дургүйцэх, үзэн ядах, эсвэл ойшоож сайшаах, магтаж бахархах зэрэг сэтгэл хөдлөлөөс үүдэлтэй утгын өнгө ялгараа нь яруу илэрхийлэх арга болж байгааг судалгааны гол оногдохуун болгох учиртай ажээ.

⁶ В.Н.Телия-гийн өмнө дурдсан бүтээлээс үзнэ үү.

⁷ А. Wierzbicka. Semantic primitives. Frankfurt a. M., Athenium, 1972, A Lingua mentalis: The semantic of natural language, Sydney: Acad, Press, 1980 бүтээлээс үзнэ үү.

Дүгнэлт

Хэлний илэрхийллийн утгыг зөв таньж тайлбарлахын тулд уг илэрхийлэл ямар ямар бүрэлдүүлбэртэй байж, тэдгээр нь өөр хоорондоо ямар харьцаа хамааралтай болохыг юуны урьд мэдэх хэрэгтэй болно. Ингэхдээ өгүүлэгч, сонсогч хоёрын харилцааны эрэмбийг заавал хэм тэнцүү харгалзаж үзэх шаардлагатай байдаг. Учир нь хэлний илэрхийлэл болгон нь ямар нэг юм үзэгдлийн тухай жирийн мэдээлэл байх нь огт үгүй. Харин уг зүйлийг сайн муу, сайхан муухай, хэрэгтэй хэрэггүй, хүсмээр үзэн ядмаар гэх мэтчлэн ямар нэг байдлаар үнэлж цэгнэх нь зайлшгүй байна. Нөгөөтэйгүүр, уг юм үзэгдэл өгүүлэгчийн хэрэгцээ ашиг сонирголоос хамааран эерэг сөрөг үнэлэмжтэй байх төдийгүй чухам тийм байгаад нь дургүйцсэн, үл тоомсорлосон, үзэн ядсан, эсвэл ойшоож таашаасан, баярлаж бахархсан зэрэг сэтгэл хөдлөлийн шинж бас давхар илрэх учиртай байна. Сонсогч ч гэсэн өгүүлэгчийн энэ санааг дарааллынх нь хувьд эсрэг эрэмбээр таамаглаж ядахдаа төстэй, чадвал ижил танилт дүгнэлтэд хүрэх учиртай байна. Харилцаанд илрэх энэ утга нь чухамдаа хүний танин мэдэх үйл ажиллагааны цар хүрээ, төрөл зүйл, онцлогтой шууд холбоотой учраас зөвхөн хэлний илэрхийллээр зууч болгож байгаа болохоос биш сэтгэцийн дотоодод үүсч байгаа давхар давхар хийсвэрлэл бүхий харилцааны тодорхой нөхцөл байдлаас шалтгаалж, утгын үарим бүрэлдүүлбэр нь тод илэрч, зарим нь дам илэрсэн байж болно. Хамгийн гол нь өгүүлж байгаа зүйлдээ өгүүлэгчийн талаас хандаж байгаа хандлага, үнэлэмж, сэтгэл хөдлөлийн шинж байдлыг бүрэн дүүрэн таньж мэдэх сэтгэцийн үйл ажиллагааны эрэмбийг зөв тодорхойлох явдал чухал гэж үзнэ.

SUMMARY

In this article, the author discusses the expressive meaning on cognitive approach. We should know interrelation and ratio of elements in expressive meaning to explain correctly expressive meaning. Therefore, it is necessary to observe the communicational hierarchy of the speaker and listener. This is because all expressive meaning cannot be defined through simple (normal) information. On the other hand, a phenomenon can be observed when expressing the speaker's values and emotions influences directly to the listener's emotional attitude such as annoyed, hatred, feel resentful, humiliate, satirize, curse, be proud of, and esteem. This meaning in communication is related to range and type is an important feature of cognitive process. The significance of such factors as speaker's attitude towards topic spoken, its evaluation, overall recognition of mental activities, as well as psychological categorization on proper basis overwhelmingly emphasized.